



ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/42

Жаргалант сум

Ээлжит IV хуралдааны тов тогтоох,
хэлэлцэх асуудлыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит IV хуралдааныг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09.00 цагт хуралдуулахаар тов тогтоосугай.

2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит IV хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл ажлыг ханган зохион байгуулахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ц.Ганбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны
өдрийн ~~11~~ дугаар захирамжийн хавсралт

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ IV ХУРАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэлэлцэх асуудал	Хуралдаанд асуудал танилцуулах албан тушаалтан
1	Сумын 2025 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл	Санхүү албаны дарга Ч.Буянаа
2	Ахмад настны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай	Ахмадын хорооны дарга О.Цэрэндулам
3	Соёлыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай	Соёл мэдээллийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болд
4	Ногоон Жаргалант хөтөлбөрийг шинэчлэн батлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай	Байгаль хамгаалагч Н.Бямбажин
5	Боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай	Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Батбаяр, 3-р цэцэрлэгийн эрхлэгч А.Ганцолмон
6	Эрүүл Жаргалантчууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай	Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч н.Насанжаргал
7	Малжуулах хөтөлбөрийг шинэчлэн батлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Алтангэрэл
8	Жаргалантын ногоочид хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Баасанжаргал
9	Эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрийг батлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай	Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ц.Дэлгэрмаа
10	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хийгдэх ажлын эрэмбэ батлах тухай	ЗДТГ-ын мэргэжилтэн Б.Буянжаргал
11	Жаргалант сумын 2026 оны төсөв батлах тухай	Засаг дарга Л.Учрал
12	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга	Байгаль хамгаалагч Н.Бямбажин